



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ДААЛГАВАР

2020 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 03

Ховд

2020-2021 оны Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт,
хот, төв суурин газрын өвөлжилтийн
бэлтгэл хангах тухай

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын эрсдэлийн үнэлгээний байдал, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамнаас өгч байгаа чиглэл, анхааруулга нь төрийн бүх шатны удирдлага, албан хаагчдын бэлэн байдлыг хангаж, түүнд хяналт тавьж ажиллахыг зөвлөж байна.

Тиймээс хот суурин, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсролын салбар, дэд бүтцийн салбар байгууллагуудын ажлыг эрчимжүүлж, бэлтгэлээ бүрэн хангаж ажиллах зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “л” заалтыг үндэслэн **ДААЛГАХ** нь:

Нэг. Сум, багийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн салбар байгууллагын дарга, мэргэжилтэн нарт.

1.1 Сумдын бэлтгэвэл зохих өвс тэжээлийн аюулгүйн нөөцийн хэмжээг хавсралтаар баталсугай.

1.2 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах сум, багийн түвшинд ажиллах ажлын хэсгийг 2020 оны 08 дугаар сарын 05-ны дотор байгуулж, ажлын төлөвлөгөө гарган баталж, биелэлтэнд нь хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг цаг тухай бүр нь авч мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах.

1.3 Үер, усны аюулаас туйлын болгоомжтой хянуур байх.

1.4 Хадлангийн талбайн зураглалыг сум бүр гаргаж хуваарилалтыг зөв зохион байгуулж иргэд, аж ахуйн нэгж, малчдын хоршоо, нөхөрлөлд түр эзэмшүүлэн хяналт тавьж 8 дугаар сарын 10-аас 9 дүгээр сарын 15-ны дотор хадлан бэлтгэх төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх.

1.5 Хадлан, гар тэжээл, хужир шүүг хавсралтанд заасан төлөвлөгөөний дагуу бэлтгэхэд малчид, тариаланчид, хадланчид мал бүхий иргэд, аж ахуйн

нэгж, байгууллагуудын алба хаагчдыг татан оролцуулж нийт малын 30 хувийг 1-2 хоног тэжээхээр тооцон орон нутгийн нөөц бүрдүүлэн шаардлагатай цэгүүдэд байршуулан хяналтанд авч бүртгэх.

1.6 Хадлан тэжээл бэлтгэх техник тоног төхөөрөмжийн үйлчилгээний аюулгүй байдлыг бүрэн хангуулах.

1.7 Өөрийн сумын нутгаас өвс бэлтгэх боломжгүй сумдад хадлангийн нөөц талбай бүхий бусад сумдын удирдлагатай хадлангийн гэрээгээр ашиглах өвс, тэжээл бэлтгүүлж худалдан авах, хужир шүүг өвс тэжээлээр солилцох зэргээр тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

1.8 Өвөл, хаврын бэлчээрийн даацад тулгуурлан сум дундын болон аймаг дундын отрын бүс нутгууд, хилийн зурvas газар, байгалийн тусгай хамгаалалттай газруудад отроор өвөлжих, хаваржих өрх, малын тоо тохирон холбогдох газар, аймаг, сумдын удирдлагуудтай гэрээ хэллэлийг 10 дугаар сард багтаан зохион байгуулах.

1.9 Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчин, ариутгал, халдвартгүйжүүлэлтийн арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, мал эмнэлэгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж шуурхай удирдлагаар хангаж ажиллах.

1.10 Малчин өрх бүрийг малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлшээ бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлүүн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэргээр мал өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангаж ажиллах.

1.11 Нийт хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироог бүрдүүлж, дутагдалтай хээлтүүлэгчийг нөхөн тавих хуц, ухныг 12 дугаар сарын 10-ны дотор багтаан ялгаж, малчдын саналын дагуу суурь зохион байгуулж ажиллах.

1.12 Сум, багийн харилцаа холбооны найдвартай ажиллагааг хангаж, цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг иргэд, малчдад тогтмол хүргэж байх.

1.13 Намрын ургац хураалтанд шаардагдах хүн хүч, техникийн бүрэн бүтэн байдал, хүрэлцээ хангамж, шатах тослох материалын нөөц бүрдүүлэхэд анхаарч, ургацыг хаягдал багатай хураан авах, хадгалах байр сав бэлтгэх.

1.14 Мал, мах бэлтгэх ажлыг эрчимжүүлэх талаар малчдад сайтар ойлгуулан тарга хүч муутай малыг бордож борлуулах, энэ ажилд мал, мах бэлтгэдэг компани, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжтэй холбоо тогтоон гэрээ байгуулах замаар газар дээр нь борлуулах ажлыг зуучлан зохион байгуулах.

2. Энэхүү албан даалгаврын заалт бүрээр хэрэгжилтийг хангаж явцын мэдээг 2020 оны 8 дугаар сарын 10-аас эхлэн 10 хоног тутам Хүнс, хөдөө аж ахуйн газарт мэдээлж, нэгдсэн дүнг 10 дугаар сарын 10-ны дотор Засаг даргын зөвлөлд танилцуулахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/ нарт үүрэг болгосугай.

Хоёр. Төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангах тухай

2.1 Аймгийн боловсролын салбарын хичээлийн байр, цэцэрлэгийн урсгал засвар, цахилгаан, дулаан хангамж, цэвэр ус, анги танхимын тохижилтыг 8 дугаар сарын 25-ны дотор бүрэн ханггуулж, хүлээн авахыг аймгийн Засаг даргын орлогч /Ч.Уранчимэг/, Боловсрол, соёлын газрын дарга /М.Пүрэвхүү/, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

2.2 Сургуулийн орчмын аюулгүй байдал, халдварт хамгаалалт, орчны эрүүл ахуйг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж хянуулахыг бүх захирал, эрхлэгч нарт даалгаж хяналт тавихыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /П.Эрдэнэчuluун/, Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/ нарт даалгасугай.

2.3 Албан байгууллага, айл өрхүүдийн дулааны шугам сүлжээний урсгал болон их засварын ажлыг 8 дугаар сарын 20-оос 9 дүгээр сарын 15-ны дотор бүрэн хийж дуусган шалгаж, хүлээн авах мэргэжлийн баг гарган хянаж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

2.4 Жилийн хэрэгцээний түлш, нүүрсний 40-өөс доошгүй хувийн татан авалтыг сум, байгууллага, дулааны станцууд бүрэн тооцож 9 дүгээр сарын 25-ны дотор хэрэгжүүлж татан авч нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж хяналт тавьж, ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/, сум, байгууллагын удирдлагуудад даалгасугай.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудад ДААЛГАХ нь:

2.5 Барилга байгууламжийн урсгал засвар, их засварын ажлыг 9 дүгээр сарын 1-ний дотор дуусгаж, хаалга цонх, гадна худаг, засвар үйлчилгээг хийлгэж хүлээн авах.

2.6 Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга угсралтын их засварын ажилд хяналт хийж, зөвлөн туслах ажлын хэсгийн хуваарийг гаргаж ажиглагч байгууллагуудын дотоод хяналтыг тогтмол хийлгэж чанарт нь онцгой анхаарч ажиллах.

2.7 Сум, байгууллага, айл өрхийн цахилгаан шугам сүлжээний засвар үйлчилгээг 8 дугаар сард багтаан хийж иргэн, аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллахыг Ховд Цахилгаан түгээх сүлжээ ХХК /Ш.Арстан/, сум, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.8 Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээг 8 угаар сард багтаан хийж, иргэн, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллахыг Нийтийн аж ахуй үйлчилгээний “Шим-Ус” Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /Т.Баатарзориг/, аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.


Гурав. Өвөлжилтийн бэлтгэлийг бүрэн хангах, дэмжлэг үзүүлж хяналт тавих хөрөнгө санхүүгийн талаар:

3.1. Өр барагдуулж өвөлжилтийн бэлтгэлийг хангах зарим арга хэмжээнд санхүүгийн эх үүсвэр гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ нарт үүрэг болгосугай.

3.2. Өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөт ажлын явцын талаар иргэдэд тогтмол мэдээлж, дүнг нээлттэй танилцуулж байхыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

3.3 Өвөлжилтийн бэлтгэлийн нэгдсэн дүнг 2020 оны 10 дугаар сарын 10-ны дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ




Т.ЖАРГАЛСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 17-ны өдрийн
03 дугаар албан даалгаврын
хавсралт

**ХАДЛАН, ТЭЖЭЭЛ, ХУЖИР ШҮҮ БЭЛТГЭХ
НӨӨЦЛӨХ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Сумдын нэр	Бэлтгэх хадлан /тн/	Бэлтгэх гар тэжээл /тн/	Бэлтгэх хужир шүү /тн/	Сумын аюулгүй нөөцөд бэлтгэх	
					Өвс /тн/	Тэжээл /тн/
1	Алтай	1500	150	414	50	30
2	Булган	22000	450	698	50	30
3	Буянт	8000	350	573	50	30
4	Дарви	800	200	499	50	30
5	Дөргөн	1200	200	329	50	30
6	Дуут	100	100	351	50	30
7	Зэрэг	3000	300	422	50	30
8	Манхан	2500	350	599	50	30
9	Мянгад	6000	350	614	50	30
10	Мөст	100	100	527	50	30
11	Мөнххайрхан	100	100	313	50	30
12	Үенч	6000	300	342	50	30
13	Ховд	5500	300	398	50	30
14	Цэцэг	100	100	384	50	30
15	Чандмань	1500	300	542	50	30
16	Эрдэнэбүрэн	2500	250	459	50	30
17	Жаргалант	700	100	291	50	30
Дүн		61600	4000	7756	850	510

-оОо-



Ховд аймгийн Засаг даргын 2016
оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн
A/43 дугаар тушаалын 4 дүгээр
хавсралт

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭРИЙН
ТӨСӨЛД ӨГӨХ ВИЗ /БУСАД АСУУДАЛ/

1. Шийдвэрийн төсөл боловсруулсан хэлтэс, тасаг, ажилтны нэр, албан тушаал:

Xoxvtx x.Basanchir

2. Захиргааны шийдвэрийн хэлбэр, утга: /Утгыг тодорхойлон бичих/

Айлан даалтавч

3. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч: /нэг бүрчлэн нэрлэн бичих/

1.Энхбат, 2.Түншээвэр, x.Basanchir

4. Шийдвэр гаргахад шаардагдах нөхцөл байдлуудыг тогтоосон, нотлох баримт цуглуулсан, сонсох ажиллагаа явуулсан эсэх: /Тайлбар, нотлох баримтыг бичих/

Хийгдэхийн шийдвэр гаргахад шаардагдах нөхцөл байдлуудыг тогтоосон, нотлох баримт цуглуулсан, сонсох ажиллагаа явуулсан эсэх: /Тайлбар, нотлох баримтыг бичих/

5. Шийдвэрийн төсөл боловсруулсан албан тушаалтныг шууд харьяалах газар, хэлтсийн даргын нэр, гарын үсэг, дүгнэлт:

~~Хууль зүйн үндэслэлийн талаарх дүгнэлт~~ /Засаг даргын Тамгын газрын дарга хянах/

6. Хууль зүйн үндэслэлийн талаарх дүгнэлт: /Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, боломжгүй бол тус хэлтсийн албан хаагч хянах/

~~Хууль зүйн үндэслэлийн талаарх дүгнэлт~~ /Засаг даргын Тамгын газрын дарга хянах/

7. Шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх ажиллагааг хянасан дээд шатны албан тушаалтны нэр, гарын үсэг: /Засаг даргын Тамгын газрын дарга хянах/

~~Хууль зүйн үндэслэлийн талаарх дүгнэлт~~ /Засаг даргын Тамгын газрын дарга хянах/

8. Шийдвэр гаргахыг зөвшөөрсөн албан тушаалтны нэр, гарын үсэг: /Засаг дарга хянах/

~~Хууль зүйн үндэслэлийн талаарх дүгнэлт~~ /Засаг даргын Тамгын газрын дарга хянах/

9. Шийдвэрийн огноо, дугаар: 04 VIII 8.09m - 6
14

АЛБАН ДААЛГАВАР

**ХИЧЭЭЛИЙН ШИНЭ ЖИЛИЙН НЭЭЛТТЭЙ ХОЛБОГДУУЛАН
АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. "б" дахь заалт, 29.1.5. "в", Хог хаягдлын тухай хуулийн 9.3.10. заалтыг тус тус үндэслэн **ДААЛГАХ** нь:

Дэлхий нийтээр тархаад буй Ковид-19 цар тахлаас үүдэлтэйгээр улс, орон даяр өндөржүүлсэн бэлэн байдал зарласан энэ үед хичээлийн шинэ жил эхэлж байгаатай холбогдуулан нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг цэвэрлэх, ариутгал халдвартгүйжүүлэлт хийх, эрсдэлийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээг зохион байгуулахыг даалгаж байна.

1. Сумдын Засаг дарга нарт:

- 1.1. Хичээлийн шинэ жилийн нээлтийг утган төв суурин газруудын хог хаягдал, хогийн ургамалыг цэвэрлэх, ариутгал халдвартгүйжүүлэлт хийх ажлыг 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулах.
- 1.2. Цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг томилох ба ажлын хэсэгт байгууллагын дарга, эрхлэгч, захирал, дүйцүүлэх албаны цэргүүд, багийн дарга нарыг хамруулах.
- 1.3. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн зураглал гаргаж холбогдох байгууллага, аж ахуйн нэгжүүдэд хариуцуулан хувиарлах.
- 1.4. Цэвэрлэгээний ажилд оролцож буй ажилтан, алба хаагчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэлээр хангах.
- 1.5. Цэвэрлэгээний ажлын тайланг нэгтгэн 2020 оны 08 дугаар сарын 25-ны дотор ирүүлж, цахим хуудас болон телевизүүдээр сурталчилах.

2. Байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарт:

- 2.1. Харьяалах сумын Засаг даргын баталсан хуваарийн дагуу цэвэрлэгээний ажлыг чанартай хийж гүйцэтгэх.
- 2.2. Байгууллагын эзэмшлийн болоод ойр орчмын 100м2 талбайг цэвэрлэх.
- 2.3. Цэвэрлэгээний ажлын тайланг 2020 оны 08 дугаар сарын 22-ны дотор сумын Засаг даргад хүргүүлж, цахим хуудас болон телевизүүдээр сурталчилах.

3. Сургууль, цэцэрлэгийн захирал эрхлэгч нарт:

- 3.1. Сургууль, цэцэрлэгийн эзэмшлийн болоод ойр орчмын талбайг цэвэрлэх.
- 3.2. Сургууль, цэцэрлэгийн орчинд явган хүний гарц, сургууль, цэцэрлэгийн бус гэсэн тэмдэг, тэмдэглэгээг хийх.

3.3. Сургууль, цэцэрлэгийн ойролцоо үүссэн нүх, худаг, ил задгай цахилгааны утас зэргийг аюулгүй болгох.

4. Эрүүл мэндийн газрын дарга, Зоонозын өвчинтэй тэмцэх төвийн дарга нарт:

4.1. Ариутгал халдвартгүйжүүлэлт хийхтэй холбогдуулан сумуудын ажлын хэсгийг мэргэжил, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллах.

5. Албан даалгаварын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ